



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/32/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn Ахлах аудитор: Н.Бадамхатан Утас: 325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn Аудитор: М.Нарангэрэл Утас: 325093 Цахим хаяг: narangerelm@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР	НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА А.СЭРЭЭТЭР ТАНАА
<small>14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар, Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54, И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn</small>	
2024. 01. 23 № 303	
танай _____-ны № _____-г	

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 807,764.6 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын

талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 68 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.Аудит хийсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	23,979,629.08	27,767,813.01
33	Авлага	79,800.00	308,670.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	79,800.00	308,000.00
35	Бараа материал	23,899,829.08	27,459,143.01
354	Хангамжийн материал	23,899,829.08	27,459,143.01
35410	Бичиг хэргийн материал	5,355,740.00	4,470,350.00
35420	Аж ахуйн материал	16,897,693.01	15,594,293.01
35430	Сэлбэг хэрэгсэл	7,700.00	553,600.00
35440	Түлш, шатах тослох материал	33,896.07	300,500.00
35450	Барилгын засварын материал	52,500.00	-
35470	Бусад хангамжийн материал	1,552,300.00	6,540,400.00
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	601,067,030.72	566,422,889.09
39	Үндсэн хөрөнгө	601,067,030.72	566,422,889.09
392	Биет хөрөнгө	544,858,564.13	510,864,422.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	669,684,460.00	669,684,460.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(178,774,982.43)	(195,829,676.79)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	39,000,000.00	39,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(30,550,000.00)	(34,450,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	233,004,455.85	238,837,545.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(206,102,934.83)	(220,095,780.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	88,895,260.72	91,847,083.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	(70,297,695.18)	(78,129,209.63)
39214	Бусад үндсэн хөрөнгө	80,000.00	80,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(80,000.00)	(80,000.00)
393	Биет бус хөрөнгө	56,208,466.59	55,558,466.55
39301	Программ хангамж	16,656,900.00	16,656,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(11,402,733.41)	(12,052,733.45)
39303	Бусад биет бус хөрөнгө	50,954,300.00	50,954,300.00
3	Нийт хөрөнгийн дүн III=I+II	625,046,659.80	594,190,702.10
4	Нийт өр төлбөр	-	694,000.00
41	Богино хугацаат өр төлбөр	-	694,000.00
413	Өглөг	-	694,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	241,588.00
4136	Бусад өглөг	-	452,412.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	452,412.00
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	625,046,659.80	593,496,702.10
51	Засгийн газрын хувь оролцоо	625,046,659.80	593,496,702.10
511	Засгийн газрын оруулсан капитал	207,355,556.62	207,355,556.62
51101	Өмч: - төрийн	207,355,556.62	207,355,556.62
512	Хуримтлагдсан үр дүн	319,965,396.92	288,415,439.22
51210	Өмнөх үеийн үр дүн	319,965,396.92	319,965,396.92
51220	Тайлант үеийн үр дүн	-	(31,549,957.70)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	97,725,706.26	97,725,706.26
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн VI=IV+V	625,046,659.80	594,190,702.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үйл ажиллагааны орлогын дүн (I)	939,765,896.80	1,502,509,952.50
12	Татварын бус орлого	12,509,000.00	14,523,712.50
120	Нийтлэг татварын бус орлого	12,509,000.00	14,523,712.50
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	12,509,000.00	14,523,712.50
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	12,194,000.00	8,784,912.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	315,000.00	5,738,800.00
13	Тусламж, санхүүжилтийн орлого	927,256,896.80	1,487,986,240.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	891,144,900.00	1,425,025,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	891,144,900.00	1,425,025,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,111,996.80	62,960,940.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,111,996.80	62,960,940.00
2	Үйл ажиллагааны зардлын дүн	979,297,520.13	1,534,059,910.20
21	Урсгал зардал	979,297,520.13	1,534,059,910.20
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	917,794,514.18	1,432,524,263.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	639,244,382.35	1,068,906,618.20
210101	Үндсэн цалин	466,677,316.78	681,907,375.22
210102	Нэмэгдэл	91,329,588.31	148,391,055.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,769,499.34	222,697,786.92
210104	Урамшуулал	21,467,977.92	15,910,400.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,913,956.24	132,770,274.87
210201	Тэтгэврийн даатгал	59,362,222.35	92,996,274.48
210202	Тэтгэмжийн даатгал	6,936,496.70	10,911,063.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,410,351.22	8,319,530.93
210204	Ажилгүйдлийн даатгал	1,181,933.33	1,896,736.58
210205	Эрүүл мэндийн даатгал	13,022,952.64	18,646,669.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,656,194.76	104,006,590.76
210301	Гэрэл, цахилгаан	21,299,920.39	21,855,024.76
210303	Цэвэр, бохир ус	3,753,874.37	5,452,027.00
210304	Байрны түрээс	59,602,400.00	76,699,539.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,264,571.42	22,379,638.00
210401	Бичиг хэрэг	14,343,617.00	10,325,590.00
210402	Тээвэр, шатахуун	2,647,300.00	6,122,636.07
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,341,054.42	4,303,211.93
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,932,600.00	1,628,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	605,000.00	565,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		256,000.00
210604	Урсгал засвар	605,000.00	309,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,952,062.00	60,116,387.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,799,864.00	45,712,307.72
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,500,000.00	12,499,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	435,300.00	435,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,200.00	61,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,500.00	22,084.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	723,600.00	552,300.00
210807	Газрын төлбөр	416,598.00	833,196.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,158,347.41	43,779,054.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		350,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,158,347.41	43,429,054.13
213	Урсгал шилжүүлэг	61,503,005.95	101,535,646.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,344,397.80	14,780,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,044,401.00	12,860,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,299,996.80	1,920,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,158,608.15	86,754,746.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,158,608.15	86,754,746.52
3	Үйл ажиллагааны үр дүн (3)=(1)-(2)	(39,531,623.33)	(31,549,957.70)
5	Нийт үр дүн(5)=(3)+(4)	(39,531,623.33)	(31,549,957.70)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн (1)	927,256,896.80	1,487,986,240.00
13	Тусламж, санхүүжилтийн орлого	927,256,896.80	1,487,986,240.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	891,144,900.00	1,425,025,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	891,144,900.00	1,425,025,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,111,996.80	62,960,940.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,111,996.80	62,960,940.00
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн (2)	927,256,896.80	1,487,986,240.00
21	Урсгал зардал	927,256,896.80	1,487,986,240.00
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	865,753,890.85	1,386,450,593.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	638,217,443.23	1,057,890,059.54
210101	Үндсэн цалин	466,677,316.78	670,106,181.11
210102	Нэмэгдэл	90,302,649.19	150,672,029.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,769,499.34	176,704,930.64
210104	Урамшуулал	21,467,977.92	60,406,918.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,913,956.24	138,573,733.13
210201	Тэтгэврийн даатгал	59,362,222.35	96,045,882.93
210202	Тэтгэмжийн даатгал	6,936,496.70	11,232,759.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,410,351.22	8,986,207.87
210204	Ажилгүйдлийн даатгал	1,181,933.33	2,217,806.66
210205	Эрүүл мэндийн даатгал	13,022,952.64	20,091,075.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,656,194.76	106,580,418.88
210301	Гэрэл, цахилгаан	21,299,920.39	24,428,852.88
210303	Цэвэр, бохир ус	3,753,874.37	5,452,027.00
210304	Байрны түрээс	59,602,400.00	76,699,539.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,985,854.42	18,429,161.93
210401	Бичиг хэрэг	5,304,200.00	7,458,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,306,700.00	6,458,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,348,054.42	3,516,621.93
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,026,900.00	995,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,840,300.00	1,105,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,235,300.00	795,900.00
210604	Урсгал засвар	605,000.00	309,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	42,140,142.20	62,969,620.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,932,944.20	48,327,140.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,500,000.00	12,499,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	435,300.00	435,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,200.00	61,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,500.00	22,084.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	778,600.00	790,700.00
210807	Газрын төлбөр	416,598.00	833,196.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	902,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	902,000.00
213	Урсгал шилжүүлэг	61,503,005.95	101,535,646.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,344,397.80	14,780,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,044,401.00	12,860,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,299,996.80	1,920,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,158,608.15	86,754,746.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,158,608.15	86,754,746.52
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	207,355,556.62	97,725,706.26	359,497,020.25	664,578,283.13
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(39,531,623.33)	-
C08	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	207,355,556.62	97,725,706.26	319,965,396.92	625,046,659.80
D01	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	207,355,556.62	97,725,706.26	319,965,396.92	625,046,659.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	207,355,556.62	97,725,706.26	319,965,396.92	625,046,659.80
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(31,549,957.70)	(31,549,957.70)
D09	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	207,355,556.62	97,725,706.26	288,415,439.22	593,496,702.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,425,025,300.00	1,338,270,553.48	86,754,746.52	93.9
21	Урсгал зардал	1,425,025,300.00	1,338,270,553.48	86,754,746.52	93.9
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	1,410,238,100.00	1,323,489,653.48	86,748,446.52	93.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл	1,129,110,700.00	1,057,890,059.54	71,220,640.46	93.7
210101	Үндсэн цалин	735,733,000.00	670,106,181.11	65,626,818.89	91.1
210102	Нэмэгдэл	290,006,600.00	150,672,029.07	139,334,570.93	52.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	61,193,000.00	176,704,930.64	(115,511,930.64)	288.8
210104	Урамшуулал	42,178,100.00	60,406,918.72	(18,228,818.72)	143.2
2102	АО-оос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	146,962,100.00	138,573,733.13	8,388,366.87	94.3
210201	Тэтгэврийн даатгал	101,534,200.00	96,045,882.93	5,488,317.07	94.6
210202	Тэтгэмжийн даатгал	11,357,000.00	11,232,759.85	124,240.15	98.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,085,600.00	8,986,207.87	99,392.13	98.9
210204	Ажилгүйдлийн даатгал	2,271,400.00	2,217,806.66	53,593.34	97.6
210205	Эрүүл мэндийн даатгал	22,713,900.00	20,091,075.82	2,622,824.18	88.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,676,900.00	106,580,418.88	7,096,481.12	93.8
210301	Гэрэл, цахилгаан	28,769,800.00	24,428,852.88	4,340,947.12	84.9
210303	Цэвэр, бохир ус	5,584,800.00	5,452,027.00	132,773.00	97.6
210304	Байрны түрээс	79,322,300.00	76,699,539.00	2,622,761.00	96.7
2104	Хангамж, бараа материалын зардал	4,709,300.00	4,681,921.93	27,378.07	99.4
210401	Бичиг хэрэг	1,095,200.00	1,095,200.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	720,500.00	720,500.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,898,000.00	1,870,621.93	27,378.07	98.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	995,600.00	995,600.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,105,600.00	1,105,600.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	795,900.00	795,900.00	-	100.0
210604	Урсгал засвар	309,700.00	309,700.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,673,500.00	14,657,920.00	15,580.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,200.00	15,440.00	7,760.00	66.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,499,500.00	12,499,500.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	435,300.00	435,300.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,700.00	61,700.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	29,900.00	22,084.00	7,816.00	73.9

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	790,700.00	790,700.00	-	100.0
210807	Газрын төлбөр	833,200.00	833,196.00	4.00	100.0
213	Урсгал шилжүүлэг	14,787,200.00	14,780,900.00	6,300.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,787,200.00	14,780,900.00	6,300.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	12,860,900.00	12,860,900.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,926,300.00	1,920,000.00	6,300.00	99.7
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,425,025,300.00	1,338,270,553.48	86,754,746.52	93.9
1310	Улсын төсвөөс санхүүжих	1,425,025,300.00	1,338,270,553.48	86,754,746.52	93.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,425,025,300.00	1,338,270,553.48	86,754,746.52	93.9
62	Ажиллагсдын тоо	57	57		100.0
620001	Удирдах ажилтан	1	1		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	48	48		100.0
620003	Үйлчлэх ажилтан	8	8		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	62,960,940.00
21	Урсгал зардал	62,960,940.00
210	Бараа,ажил үйлчилгээний зардал	62,960,940.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,747,240.00
210401	Бичиг хэрэг	6,363,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,737,740.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,646,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,311,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	48,311,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	902,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	902,000.00
II	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	62,960,940.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,960,940.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,960,940.00
IV	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 213,557.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажил гүйлгээг шууд зардлаар бүртгэж тайлагнасан.	1	49,229.4			1	42,229.40	1	42,229.4		
Хөрөнгийн буруу дансанд бүртгэсэн.	1	52.5			1	52.50	1	52.5		
Хөрөнгийн ангиллыг буруу бүртгэсэн.	1	3,668.4			1	3,668.4	1	3,668.4		
Тогтмол зардлын дансны бичилтийг буруу хийсэн.	1	2,149.0			1	2,149.0	1	2,149.0		
Урьдчилгаа цалингийн зардлыг бууруулж бүртгэсэн.	1	140,422.9			1	140,422.9	1	140,422.9		
Тайлант онд авлага, өр төлбөрийг дутуу бүртгэж тайлагнасан.	1	1,556.4	1	1,556.4			1	1,556.4		
Тайлант онд татвар ногдох орлого, нийгмийн даатгалын шимтгэл, татварын зардлыг бууруулж тайлагнасан.	1	16,478.5			1	16,478.5	1	16,478.5		
Дүн	7	213,557.1	1	1,556.4	6	205,000.7	7	206,557.1		

Аудитаар нийт 807,764.6 мянган төгрөгийн зөрчил² илэрч 5,568.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 12,229.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 789,967.2 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан хаагчид цалин хөлсийг илүү тооцож олгосон.	1	1,452.0	1	1452.0				
Тайлант онд албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон	1	4,116.0	1	4,116.0				
Харилцагч 3 байгууллагатай 7,541.5 мянган төгрөгийн тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй, 3 байгууллагатай 4,687.9 мянган төгрөгөөр тооцооны үлдэгдлийг зөрүүлсэн.	1	12,229.4			1	12,229.4		

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанаргүй хийж гүйцэтгэсэн, хөрөнгийн тооллогыг бүрэн гүйцэт хийгээгүй, эзэмшигчдэд хүлээлгэн өгсөн карт дутуу, хөрөнгийн тооцоог данс тус бүрээр бодоогүй, өмч хамгаалах зөвлөлийн хурлын протокол байхгүй, ашиглах боломжгүй хөрөнгийн жагсаалтыг гаргаж бэлтгээгүй.	1	776,375.7					1	776,375.7
Байгууллагын дансанд бүртгэлтэй боловч байгууллагад хураагдсан хашааг тоолж баримтжуулаагүй, байгууллагын дансанд бүртгэлтэй боловч үндсэн хөрөнгийн шинж чанар хангаагүй хөрөнгийг данснаас хасаагүй.	1	5,217.5					1	5,217.5
Байгууллагыг түрээсийн гэрээнд барьцаа байршуулсан гэсэн боловч байршуулсан барьцаа санхүүгийн тайлан бүртгэлд тусгагдаагүй, илүү төлбөр шилжүүлсэн боловч зардлын зориулалт тодорхойгүй.	1	2,049.0					1	2,049.0
Тайлант онд зохион байгуулсан сургалтын зардлын тооцоолол болон анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг зардлаар бүртгэж тайлагнасан.	1	4,992.0					1	4,992.0
Тайлант онд албан хаагчдын хувийн автомашинд шатахуун хийж, зардлаар бүртгэж тайлагнасан.	1	1,333.0					1	1,333.0
Дүн	8	807,764.6	2	5,568.0	1	12,229.4	5	789,967.2